

**“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2022 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2022.11.25

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
ТАВ. ЗАСАГЛАЛ						
1	5.2.Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.	5.2.18. Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2020 - 2050	-	Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	<p>ТӨБЗГ - ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьсан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчим болон "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнд нийцүүлэн боловсруулсан.</p> <p>Уг хуулийн шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Үндсэн хуульд нийцүүлэн тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчдийн эрх</p>

					<p>хэмжээг шинэчилж, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, харилцан уялдаа холбоог анхаарсан бөгөөд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхой тусгасан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн анхдагч төслийг ХЗДХЯ-аас УИХ-д өргөн барьсан бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгэгдэж байна. Уг хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр нарийвчлан тодорхой тусгасан.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд заасны дагуу бүртгэх, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Төрийн өмчийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх, хамгаалах чиглэлээр ХЗДХЯ-ны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл томилогдон холбогдох журам батлуулахаар ажиллаж байна.</p> <p>Худалдан борлуулахаар шийдвэрлэсэн өмч хөрөнгийн дуудлагын худалдаанд иргэдийг оролцох боломжоор хангаж, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дуудлага худалдааны зар, мэдээллийг зарлаж, нээлттэй дуудлагын худалдаанд оролцуулж байна. Нээлттэй дуудлага худалдаанд ялагч болсон тохиолдолд өмчлөх эрхийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 90%</p>
2	5.2.19. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.	2020 - 2050		Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд	<p>ТӨБЗГ – ТӨҮЗХ</p> <p>Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр</p>

				<p>нээлттэй худалдах ажлыг эхлүүлэх</p> <p>“Төрийн банк” ТӨХХК-ийн 20 хүртэлх хувийг үе шаттайгаар олон нийтэд арилжаалах, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 34 хүртэлх хувийг 2022 оны IV улиралд багтаан, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Үндэсний давхар даатгал” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ, авто замын засвар, арчлалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит 20 хувьцаат компани зэрэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 34 хүртэлх хувийг 2023 оны IV улиралд багтаан тус тус нээлттэй худалдахаар шийдвэрлэсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолоор дээр дурдсан 25 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжиж, олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Үг тогтоолоор хувьцааны арилжааг хийх бэлтгэл ажлыг хангах, мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах асуудлыг Үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, үйцэтгэх захирал нарт зөвшөөрсөн байна.</p> <p>Засгийн газрын тогтоол шийдвэрт заасан хугацаанд зохих арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>“Төрийн банк” ТӨХХК-ийн хувьд холбогдох эрх бүхий байгууллагуудын шийдвэрүүд гарч, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд арилжаалах ажлыг эхлүүлсэн бөгөөд анхдагч арилжаа амжилттай явагдсан.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 90%</p>
--	--	--	--	---

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт шууд хамаарах 1 бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 2 арга хэмжээ тусгагдсан болно. Эдгээр зорилт, арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийн дүнг дор товчлон танилцуулав.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр):

Нийт арга хэмжээ (заалт)-ний тоо – 2; Үүнээс: 90 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ – 90.0 % буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” дүнтэй байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ